

ЗДТГ-ын хамт олны 2018 оны 09-р сарын
18 ны өдрийн хурлаар шинэчлэн батлав.



**Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын
ЗДТГ-ын дотоод журам**

Зорилго: Байгууллагын холбогдох ажилтнуудын эрх, үүрэг, ажил үүргийн хуваарь, хариуцлага болон нийгмийн баталгааг хангахтай холбогдож хуулиар зөвшөөрөгдсөн харилцааг зохицуулахад оршино.

Хамрагдах хүрээ: Засаг даргын дэргэдэх албадууд, Багийн засаг дарга нар, Засаг даргын тамгын газар, нийт албан хаагчид орно

Нэг. Ажилтан, албан хаагчдын үүрэг

- 1.1. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хариуцсан ажлыг баталсан хуваарь, чиг үүргийн дагуу нягт нямбай, шуурхай гүйцэтгэж эргэж тайлагнаж байна.
/хол/мат хамт/
- 1.2. Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төрийн албан хаагчийн эрхэмлэх 9 зүйл, ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.
- 1.3. Байгууллагын эд хөрөнгийг ариг гамтай эдэлж, эвдэж үрэгдүүлсэн тохиолдолд байгууллагыг хохиролгүй болгож, төсвийг үр ашигтай зарцуулна.
- 1.4. Мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж, албан бичиг баримтыг боловсруулахдаа холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг сайтар судалсны үндсэн дээр агуулга сайтай стандартын дагуу боловсруулна.
- 1.5. Зохион байгуулагдаж байгаа нийтийн хөдөлмөр, соёл хүмүүжлийн ажилд идэвхтэй оролцож, түр хугацаагаар эзгүй байгаа ажилтныг орлон гүйцэтгэж бие биенийхээ ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж багаар ажиллах зарчмыг баримтлан ажиллана.
- 1.6. Ажилтан, албан хаагч нь үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээ, ёс зүйн хариуцлагын гэрээ, ажлын байрны тодорхойлолт, дотоод журмын дагуу хүлээсэн үүргээ биелүүлж, гаргасан шийдвэрийнхээ төлөө хариуцлага хүлээж, удирдах удирдуулах ёсыг баримтлан ажиллана.
- 1.7. Тамгын газрын ажилтан, албан хаагчтай холбоотой аливаа асуудлыг аппаратын хурлаар хэлэлцэж шийдвэрлэсний дараа холбогдох байгууллага, ёс зүйн хороонд уламжилж шийдвэрлүүлнэ.